# ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН БОДЛОГО, СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨЛТ, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА

## Б.УРТНАСАН

ЭМГ-ЫН
УТХ-ИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ,
ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ,
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ХАРИУЦСАН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

# НЭГ. ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН СТРАТЕГИ, ХЭРЭГЖИЛТ

# СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ



Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/609 “Эрүүл мэндийн салбарын 2022-2025 оны стратеги төлөвлөгөө” нь 4 үндсэн чиг үүрэг, 9 зорилттой хэрэгжиж байна.

Энэ стратеги нь Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор тусламж үйлчилгээний төвлөрлийг сааруулан орон нутгийн эрүүл мэндийн байгуулллагын чадавхийг бэхжүүлж гүйцэтгэлийн санхүүжилт, цахим мэдээллийн тогтолцоог бүрэн нэвтрүүлж эрүүл мэндийн чанар хүртээмжтэй үр дүнтэй тогтолцооны шинэчлэлийг хийнэ.



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2022 оны 12 сарын 15 өдөр Дугаар А/609 Улаанбаатар хот

Эрүүл мэндийн салбарын 2022-2025 оны стратеги төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6.5 дахь заалт, Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эрүүл мэндийн салбарын 2022-2025 оны стратеги төлөвлөгөө”-г хавсралтаар батлсугай.

2. “Эрүүл мэндийн салбарын 2022-2025 оны стратеги төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг нэгдсэн удирдлага, мэргэжил арга зүй, зохион байгуулалтаар ханган ажиллахыг тус яамны бүх газар, хэлтсийн дарга нарт даалгасугай.

3. Стратеги төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээг аймаг, нийслэлийн үйл ажиллагааны төлөвлөгөө, байгууллагын стратеги төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхийг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтийг 2 жил тутамд нэгтгэхийг Бодлого төлөвлөлтийн газар /Б.Буянтогтох/-т, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхийг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /С.Төгсдэлгэр/-т тус тус даалгасугай.

САЙД С.ЭНХБОЛД

# СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

ЭМГ-ын дунд хугацааны хөгжлийн “Стратеги төлөвлөгөө 2021-2024 он “ 6 үндсэн чиг үүрэг, 16 зорилттой хэрэгжиж байна. Энэ стратеги нь Байгууллагын чадавхийг бэхжүүлэх, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах, хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, эмч, эмнэлгийн ажиллагсдыг хөгжүүлэх, нийгмийн баталгааг хангаж ажиллахад эрүүл мэндийн байгууллагуудад бүх талын дэмжлэг үзүүлнэ.


ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

2021-2024 он

Төлөвлөгөөг баталсан:

Аймгийн Засаг дарга ............ Төсвийн Ерөнхийлөн захирагч /С.Батжаргал/

(албан тушаал) (гарын үсэг)

(огноо)

Тэмдэг ..............................

Төлөвлөгөө боловсруулсан:

Эрүүл мэндийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч ............ Төсвийн шууд захирагч /Д.Сүхээ/

(албан тушаал) (гарын үсэг)

(огноо) 2021.04.06

Тэмдэг

# СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ



## ГУРАВ. АЛСЫН ХАРАА, ЭРХЭМ ЗОРИЛГО

Хүний хөгжлийг дэмжсэн, амьдрахад таатай, тэргүүлэгч аймаг болно.

### ЭРХЭМ ЗОРИЛГО-MISSION

Амьдрах таатай орчныг хангасан, экологийн тогтвортой байдлаа хадгалсан, аялал жуулчлал, хөдөө аж ахуй, уул уурхай хөгжсөн Монгол Улсын тэргүүлэх аймаг болно.

### ҮНЭТ ЗҮЙЛ

- **Иргэн төвтэй байх –** Иргэдийн эрх ашгийг хамгаалж, тэдний дуу хоолойг сонсох
- **Хууль дээдлэх –** Хуулийг дээдлэн хэлбэрэлтгүй сахин биелүүлж, хуульд нийцсэн шийдвэр гаргах
- **Тэгш шударга байх –** Нийтийн эрх ашгийг эрхэмлэн, иргэдийг адил тэгш боломжоор хангах
- **Ил тод байх –** Хуулиар нууцын зэрэглэлд хамаарахаас бусад мэдээллийг иргэдэд нээлттэй, ил тод, ойлгомжтой хүргэх
- **Мэргэшсэн, хариуцлагатай байх –** Ажил үүргээ мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэх

ЭРДЭНЭТ

## ОРХОН АЙМГИЙН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

ТӨЛӨВЛӨГӨӨГ БАТАЛСАН:

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ М.ТҮМЭНЖАРГАЛ

# Стратеги төлөвлөгөөний хэрэгжилт:



- Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуулийг батлуулсан

- Товлолт дархлаажуулалтад хүний папилома вирусын эсрэг вакцин нэвтрүүлсэн

- Аймаг дүүргийн эмнэлгүүдийн хүчин чадлыг нэмэгдүүлж, төвлөрийг сааруулах, орон нутагтаа оношилуулж эмчлэх боломжийг бүрдүүлсэн /хавдрын хими, бай эмчилгээг нэвтрүүлсэн/

- Өрх сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдэд мобайл тусламж үйлчилгээг өргөжүүлсэн: Жаргалант сум, Мөнхийн гэгээ, Учралтбаяр, Энхжихмандивраа , Үйлсбадрах, Мөнх-Сүндрэл/5/

- Туслах сувилагчийн орон нутагт бэлтгэсэн: ЭТҮГЭН их сургуультай хамтран БОЭТ-д 20 туслах сувилагч бэлтгэсэн.

ЭМГ-ын Стратеги төлөвлөгөөний хэрэгжилт-97.5%

# ISO 9001-2015 стандарт

Олон улсын чанарын менежментийн тогтолцоо ISO 9001-2015 стандартыг 4 ӨЭМТ, 3 хувийн хэвшлийн ортой эмнэлгүүдэд нэвтрүүлж, 2 удаагийн баталгаажилтад оруулан, 3 байгууллага гэрчилгээгээ гардан авлаа. Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001-2015 стандартын хүрээнд:




- Дотоод аудитор бэлтгэх сургалтыг орон нутагтаа 2 удаа зохион байгуулж нийт ЭМС-ын 53 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд дотоод аудиторын гэрчилгээг олголоо.

- G2G сургалтын төвийн тэргүүлэх аудиторуудтай хамтран чанарын менежментийн тогтолцоо ISO 9001-2015 стандартын сургалтыг нийт 155 албан хаагч нарт хийлээ.
- ШУТИС-д хийгдэж буй чанарын менежментийн тогтолцоо ISO9001-2015 стандартын сургалтад 3 байгууллагын 7 албан хаагч нарыг хамруулллаа.

- MOSHPA сургалтын төвөөс Эрсдэлийн менежментийн сургалтыг орон нутагт зохион байгуулж Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001-2015 стандартыг нэвтрүүлсэн байгууллагуудын удирлага, эрсдэл хариуцсан ажилтанг хамруулж гэрчилгээ олголоо.

# Эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмж :

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨН 2024 ОРХОН АЙМАГ







- Эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэгчдийн тоо 2017 оноос хойш 141000-аар нэмэгдсэн.
- Нэг иргэний үзүүлсэн дундаж 6.9

# ХОЁР. ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХЭРЭГЖИЛТ

# ХҮНИЙ НӨӨЦИЙН ХАНГАЛТ

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨН 2024 ОРХОН АЙМАГ

**Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн 51,8% нь төрийн өмчийн эмнэлгүүдэд, 10,4 % нь СӨЭМТ-д, 37,8 % нь хувийн хэвшлийн эмнэлэгүүдэд ажиллаж байна**

## Хүний нөөцийн мэргэшсэн байдал







Төгсөлтийн дараах үндсэн мэргэжлийн сургалтад хамрагдсан эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтний хувь 79%-д хүрч өмнөх оноос 7.6 хувиар нэмэгдсэн байна.

# ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧАДАВХЖУУЛАЛТ:

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨН 2024 ОРХОН АЙМАГ

- Аймгийн хэмжээнд 108 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг лавлагаа шатлалд болон анхан шатлалд сэлгэн ажиллуулсан байна.
- Гадаадын 11 оронд ангиогрофи, нүүр ам судлал, бөөр судлал, хавдрын мэс засал, сувилахуй зэрэг чиглэлээр нийт 60 мэргэжилтэн гадаадын өндөр хөгжилтэй оронд туршлага судалж мэдлэг чадвараа нэмэгдүүлсэн.
- Баян-Өндөр мед эмнэлэг хиймэл оюун ухаанд суурилсан умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг оношилгооны "CerviCare AI" системийг нэвтрүүлэн
- Монголын Яаралтай тусламжийн Нийгэмлэгтэй хамтран зохион байгуулж 14 багийн 70 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдаж, орчин үеийн технологи Kahoot, Quiz maiker программыг анх удаа ашиглан эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн гардан болон онолын мэдлэгийг нэмэгдүүлсэн.

# ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧАДАВХЖУУЛАЛТ:

| № | 2023 онд | 2024 |
|---|---|---|
| 1 | Эрэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэнд мэс засал, | 2024-2025 оны хичээлийн жилд улсын төсвийн санхүүжилтээр нийт 29 чиглэлээр 41 эмч, сувиалагч, эмнэлгийн мэргэжилтэн сургаж эхлээд байна. Үүнд:<br><br>Үндсэн мэргэшил: Анатомын эмгэг судлал, дотрын анагаах судлал, мэдрэл судлал, мэдээгүйжүүлэг судлал, өрхийн анагаах судлал, хүүхэд судлал, эрчимт эмчилгээ судлал, яаралтай тусламж судлал<br><br>Төрөлжсөн мэргэшил: Түлэнхийн нөхөн сэргээх мэс засал судлал, Дотоод шүүрэл судлал, Уушиг судлал, Хүүхдийн дүрс оношилгоо судлал, Мэдрэлийн мэс засал судлал, Чих, хамар хоолойн мэс засал судлал, Биостатистик судлал, Эрүүл мэндийн удирдлага, зохион байгуулалт, Мэс заслын сувилахуй, Бичил амь судлал, Хүүхдийн сувилахуй, Жирэмсэн ба төрсний дараах үеийн зөвлөгч эх баригч, Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн зөвлөгч эх баригч, Гэмтэл согогийн сувилахуй, Мэдрэлийн сувилахуй, Мэдээгүйжүүлгийн сувилахуй, Мэс заслын сувилахуй, Сэргээн засахын сувилахуй, Эрчимт эмчилгээний сувилахуй, Халдварт өвчний сувилахуй, Чихрийн шижингийн сувилахуй |
| 2 | Халдварт өвчний эпидемологи, | |
| 3 | Эх ураг судлал, Эх барих, эмэгтэйчүүдийн хэт авиан оношилгоо судлал, | |
| 4 | Хүүхдийн нүдний төрөлжсөн мэс засал, | |
| 5 | Бүдүүн шулуун гэдэсний мэс засал, | |
| 6 | Чих хамар хоолой судлал, | |
| 7 | Шүүхийн анагаах ухаан судлал , | |
| 8 | Дүрс оношилгоо судлал, | |
| 9 | Өрхийн анагаах судлал, | |
| 10 | Нүд судлал,.<br>Эрчимт эмчилгээ судлал, | |
| 11 | Гэр бүл төлөвлөлтийн зөвлөх эх баригч, | |
| 12 | Сэргээн засал судлал, | |
| 13 | Монголын уламжлалт анагаах ухааны дотор судлал зэрэг мэргэшлээр суралцсан | |

# НИЙГМИЙН АСУУДАЛ:



**Хүний нөөцийн тогтвор суурьшлийн төлөв байдал -2023 ОН**




Шилжин ирэгч-64




2022-2023 онуудад салбарын хэмжээнд 14 эмнэлгийн ажилтанг түрээсийн орон сууцад оруулсан.

# “ЭМЧ” ХӨТӨЛБӨР 2021-2024
# /АИТХ-ЫН 2021 ОНЫ 8-Р ТОГТООЛ/

- **Нийт ажилтнуудын тоо:2006**

***/эмч-440, сувилагч-487, эм зүйч-162, тусгай дунд мэргэжилтэн-194/***

- **Нарийн мэргэжлийн эмч нарын уулзалт зөвлөгөөн:**

***1. Гэмтэл согог судлалын олон улсын эрдмийн чуулган***
***2. Сувилахуй ба эрх зүйн төвийн бүсийн зөвлөгөөн***

**Гадаад сургалт**
**40 мэргэжилтэн**

**Дотоод сургалт-2221 мэргэжилтэн**
***/давхардсан тоогоор/***

**Эрдэм шинжилгээний хурал – 30 илтгэл хэлэлцүүлсэн**

**Дэмжлэгт хамрагдсан ажилчдын тоо- 451 ажилтан**

**Бамбайн даврын шинжилгээ-400**

**Эрүүл мэнд- 12**
**Сургалт-39**






- Мэргэжлийн зэрэгтэй эмч, эмнэлгийн мэргэжилтний хувь 27.6% болж, 2020 онтой харьцуулахад 5.5% хувиар нэмэгдсэн.
- Боловсролын магистр, докторын зэрэгтэй эмч, эмнэлгийн мэргэжилтний хувь 2020 онтой харьцуулахад 2.1 хувиар нэмэгдсэн байна.
- Судалгаа, шинжилгээний ажлыг хийсэн эмч, эмнэлгийн мэргэжилтний эзлэх хувь 20.0%, -д хүрч, 3.0 хувиар нэмэгдсэн байна.
- Гадаадад мэргэжил дээшлүүлсэн эмч мэргэжилтнүүдийн эзлэх хувь 31%-д хүрч, 8.3 хувиар өссөн.

# ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТ:





Хүлээн авсан

Цахим 92

Бичиг 38

Нийт 130 өргөдөл

Хүсэлт 38.7%

Гомдол 3.1%

Талархал 58.2%

Шийдвэрлэсэн

***Хуулийн хугацаанд нь иргэдэд хүлээлт чирэгдэл үүсгэлгүйгээр 100% шийдвэрлэсэн.***

- Өргөдөл, гомдол, шийдвэрлэлтийн мэдээлэл АЗДТГ-ын шуурхай хурал, erdenet.mn, 70353511 дугаарт утсанд бүртгэгдэж мэдээлэгдэж, Эрүүл мэндийн газрын www.or.mohs.gov.mn цахим хуудсанд байршуулж ил тод байдлыг хангаж ажилласан.
- Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайланг аймгийн ЗДТГ-т хугацаанд нь хүргүүлэн ажилласан.

# ГУРАВ. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

# Эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалтын хэлбэр





# Хөрөнгө оруулалтын дүн шинжилгээ:







Нийт хөрөнгө оруулалтын 70-иас дээш хувийг тоног төхөөрөмж, барилгын засварууд эзлэж байна. ЭМС-ын тоног төхөөрөмжийн хангалт 95%-д хүрсэн байна.

# Хөрөнгө оруулалтын дүн шинжилгээ:




Төсөл хөтөлбөрийн санхүүжилтийн 80% -нь эмнэлгийн тусламж үйлчилгээнд зарцуулж, 20% нь нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд зарцуулсан байна.

# НИЙТЛЭГ ТУЛГАМДСАН АСУУДЛУУД



- Эрүүл мэндийн байгууллагуудын эрх зүйн баримт бичгүүдийн хоорондын уялдаа холбоо бага
- Төлөвлөгөөний хэрэгжилтийг бодитоор үнэлдэггүй, үнэлгээний аргачлалыг хэрэглэхгүй байна.
- Хүний нөөцийн тогтвортой байдлыг хангахад байгууллагын удирдлагын санал санаачлага дутмаг
- ЭМБ-ын өрсөлдөх чадвар сул, нэг хэвийн хэвшмэл арга барилтай, хүний нөөцийг сургаж мэргэшүүлэх байдал нь зарим хувийн хэвшлийн эмнэлгүүдэд дутмаг
- Эмнэлгүүдийн нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ орхигдсон.
- Цахим програмыг бүрэн ашиглахгүй байна./ эмнэлгүүдийн эмч нар хөнгөлттөй жорыг хангалтгүй бичдэгээс ӨЭМТ-үүдийн эмч нарт ачаалал үүсгэдэг/

# Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨН 2024 ОРХОН АЙМАГ

- ЭМГ-ын стратегийг шинэчлэн боловсруулах /2024-2027он/
- Эрүүл мэндийн цогц арга хэмжээг хэрэгжүүлэх:
  - -Хэвтэлтийн дараах хяналт-эрүүлжүүлэх төлөвлөгөө
  - -Асаргаа сувилгаа
  - -Шаардлагагүй хэвтэлтийг бууруулах
  - -Өдрийн эмчилгээг өргөжүүлэх
  - -Урт хугацааны сэргээн засах
- ЭМТҮ-ний чанарт дүн шинжилгээ хийж, бодлогын зөвлөмжөөр хангах
- ЭМБ-ын санхүүгийн удирдлагыг сайжруулах
- Гүйцэтгэлийн санхүүжилтийн удирдлага, хэрэгжилт зохион байгуулалтыг боловсронгуй болгох
- Эмнэлгүүд амбулаторийн үзлэгийг нэмэгдүүлж, ӨЭМТ-үүдийн ачааллыг бууруулах
- Орон нутгийн төсөл хөтөлбөрийн санхүүжилтийн 70%-иас дээш нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд зарцуулахад бодлого зохицуулалт хийх

# Анхаарал хандуулсанд баярлалаа !

www.or.moh.gov.mn

Facebook.com/Орхон ЭМГ